



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 2/17

Бөхт

Сумын “Аварга малчин” цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.11, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 сарын 03-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Сумын сайн малчин шалгаруулах болзол”-ын 4.1 дэх заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 09 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цог багийн малчин Шонхын Баянмөнх, Талын нар багийн малчин Зандансүрэнгийн Мөнхжаргалыг “Сумын хошой аварга малчин”, Цог багийн малчин Долгорын Баатар, Авирмэдийн Нэргүй, Цэгмидийн Ган-Очир, Талын нар багийн малчин Данзангийн Пүрэвдагва, Гэрэлт-Одын Өлзийхишигт, Зоригтын Бямбаа нарыг 2022 оны “Сумын аварга малчин” цол олгосугай.

2. Сумын Аварга малчны өргөмжлөл, дурсгалын зүйлд 1,008,000 (нэг сая найман мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д даалгасугай.

3. Холбогдох баримтыг үндэслэн зарцуулахыг нягтлан бодогч (Б.Сайхантуяа), нярав (Т.Батбилэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ

4823010037